


БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД



Т.АУБАКИР
2026 оны... сарын... өдөр

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



С.АМАРСАЙХАН
2026 оны... сарын... өдөр

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төслийн үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн суурь конвенцууд болон 2016 онд элсэн орсон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88 дугаар конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн хувийн албадын тухай 181 дүгээр конвенцийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, холбогдох зохицуулалтыг сайжруулах үүргийг Монгол Улс хүлээж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.6-д "Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно", зорилт 3.3-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.1-д "Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилж, салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах" гэж, 2.1.2.3-т "Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, инновацид суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн орчныг сайжруулах" гэж, 2.1.2.8-д "Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох" гэж, 2.1.2.9-т "Зайнаас, цахимаар, цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эрх зүйн орчныг сайжруулах" гэж тус тус заасан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

1. Монгол Улсын Их Хурлаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг анх 2001 онд баталж, 2011 онд шинэчлэн найруулсан. Улмаар 2011, 2012, 2014, 2015, 2016, 2017, 2021, 2022, 2023, 2024 онд нийт 20 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Гэвч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан¹ болон холбогдох судалгааны тайланд² уг хууль хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зорилтоо хангалттай биелүүлээгүй гэж дүгнэсэн. Хууль үйлчилж эхэлсэн 2011 онд ажиллах хүчний оролцооны түвшин 62.5 хувь, ажилгүйдлийн түвшин 7.7 хувь байсан бол 2024 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь, ажилгүйдлийн түвшин 5.9 хувьтай байна. Мөн эдгээр үзүүлэлтүүд эмэгтэйчүүд, залуучууд зэрэг зарим хүн амын бүлэг болон бүс нутагт дордож хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдэд дорвитой эерэг өөрчлөлт гараагүй нь дээрх дүгнэлтийг бататгаж байна.

Мөн хувьсан өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэлтийн орчин үеийн чиг хандлагууд болох цахим шилжилтийн нөлөөлөл, зайнаас ажиллах зэрэг хөдөлмөрийн харилцааны шинэ хэлбэрүүд, хүн амын насжилтыг угтсан ахимаг болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, асрахуйн эдийн засгийг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хөдөлмөрт шилжүүлэх зэрэг асуудлаарх хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалттай бус байна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн явцад “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний бүхий л үе шатанд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хүн амын зорилтот бүлгүүдийг хамруулах, оролцоог хангах зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үүссэн.

Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан болон хөдөлмөрийн зах зээлд шинээр, дахин нэвтрэхэд хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг нэн шаардлагатай байгаа иргэдийн онцлог, хэрэгцээнд тохирсон харилцан уялдаа бүхий хөдөлмөр, нийгмийн ажлын үйлчилгээ, арга хэмжээ дутмаг байна.

¹ Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээг гүйцэтгэсэн тухай тайлан.

² Н.Монголмаа. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлан /2016/, Н.Аюуш. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн агуулга, хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж /2015/, Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээний тайлан. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хөтөлбөрүүдэд хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж /2015/, Дэлхийн банк судалгааны тайлан. Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний үнэлгээ /2020/, Дэлхийн банк. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн шинжилгээ, Удирдлагын академи. Монгол Улсын уул уурхайн бус салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ /2020/, Европын Холбоо. Монгол Улсад ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн тайлан /2017/, Дэлхийн банк. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ” нэгтгэсэн тайлан /2022/.

“Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжийг уялдуулах, нийгмийн халамжид хамрагддаг хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэхэд үе шаттайгаар дэмжих, халамж авагчаас аажмаар хөдөлмөр эрхлэгч болгох үйл ажиллагаа хүртээмжгүй байна. Өнгөрсөн хугацаанд “халамжаас хөдөлмөрт” бодлогыг хэрэгжүүлснээр хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдах хүний тоо буурсан, “Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр”-т хамрагдсан зорилтот өрхүүдийн 80 гаруй хувь нь тогтмол орлоготой болж, тогтвортой амьжиргаанд хүрэх боломж бүрдсэн зэрэг бодлогын үр дүн гарсан. Цаашид “халамжаас хөдөлмөрт” бодлогыг кейс менежментэд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэлбэрээр илүү хүртээмжтэй үзүүлэх нь зүйтэй байна.

3.Хөдөлмөр эрхлэлт, боловсролын бодлогын уялдаа холбоо хангалтгүйн улмаас хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүссэн, ялангуяа мэргэжил, ур чадварын зөрүүтэй байдлаар түлхүү илэрч байгаад анхаарах шаардлагатай байна. Тухайлбал: нийт ажиллагсдын 47.0 хувь нь эзэмшсэн мэргэжлээр, үлдсэн 53.0 хувь нь мэргэжлийн зөрүүтэй ажил эрхэлдэг, улмаар тэдний орлого 10 гаруй хувийн зөрүүтэй байгаа нь судлагдсан³. Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг мөшгөн судлахад 15.7 хувь нь эзэмшсэн мэргэжилд маш тохиромжтой, 55.7 хувь нь тохиромжтой, 28.6 хувь нь тохирдоггүй буюу мэргэжлийн бус ажил эрхэлдэг болох нь тодорхойлогдсон⁴ байна.

4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг 2012-2017 онуудад жил бүр, 2018 оноос 2 жил тутам шинэчлэн баталж ирсэн. Эдгээр нь ихэвчлэн 1-2 жилийн мөчлөгтэй, хөтөлбөрийн тоо, хэрэгжүүлэх удирдамж жил бүр өөрчлөгддөг, зорилтот бүлгээ хэт нарийвчлан тодорхойлж, хүрээг хязгаарласнаас шалтгаалж аж ахуй эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг үр дүн багатай, хөнгөлөлттэй зээл олгох, эргэн төлүүлэх үйл явц хүндрэл бэрхшээлтэй, бизнесийн гараа, хөгжлийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг, зээлийн хэмжээ хангалтгүй байгаа зэрэг асуудлууд тулгамдсан шинжтэй байна⁵.

5.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалттай бус, үйлчилгээ үзүүлдэг албан хаагчдын захиргааны ажлын ачаалал их, орон тоо, бүтэц зохион байгуулалт оновчгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ “төрийн захиргааны ажилтанд суурилсан үйлчилгээ”-ээс “үйлчлүүлэгчид суурилсан кейс менежментийн үйлчилгээ”-нд шилжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйлчилгээний шаардлага, стандартыг тогтоох эрх зүйн орчин сул байна.

³ Дуламзаяа, Д.Мядаг. Хөдөлмөрийн орлого ба боловсролын зөрүү /2024/.

⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа /2019/.

⁵ Н.Батнасан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа /2018/.

6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний бүхий л үе шатанд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, дүн шинжилгээний ажлын үр дүнг ашиглах, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн хуулийн бүтэц, уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үзүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна:

- Хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёог оновчтой тодорхойлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлж, нийтлэг харилцааг тодорхойлно.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, түүнийг хэрэгжүүлэх хэлбэрийг хуульчилна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд “үйлчлүүлэгчид суурилсан кейс менежмент”-ийг нэвтрүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд төр-хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны эрх зүйн үндэслэлийг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, зорилтот бүлгийн иргэн болон ажил олгогчийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, нийгмийн бусад үйлчилгээ, арга хэмжээтэй харилцан уялдаа бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тусгах юм.

- Хүн бүр хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, насан туршийн хөдөлмөр эрхлэлт, карьерын төлөвлөлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, түүгээр дамжуулан хүргэх үйлчилгээ, арга хэмжээний төрөл, хэлбэр, дэд бүтэц, сүлжээний үйл ажиллагааг хариуцах байгууллага, бүртгэл, мэдээллийн эх сурвалж ба тайлагналттай холбоотой харилцааг зохицуулна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сангийн төсвийн төлөвлөлтийг гүйцэтгэл, үр дүнд суурилдаг болгохтой холбоотой харилцааг зохицуулна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зөвлөл, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцах төв, орон нутгийн байгууллага,

хөдөлмөрийн сургалт, судалгааны байгууллага, нийгмийн түншлэгч байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага, ажилтны эрх зүйн байдал, чиг үүрэг, оролцооны талаарх харилцааг зохицуулна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хүчин төгөлдөр болох хугацаатай холбоотой асуудлыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталснаар эрх зүй, эдийн засаг, нийгэмд дараах эерэг үр дүн гарна:

1. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай” 88 дугаар конвенцид нийцүүлэн төр болон хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хөдөлмөр эрхлэлтийн бодлого нийгмийн халамж, жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, нийгмийн бусад бодлоготой уялдах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тогтолцоо шинэчлэгдэж, үр нөлөө нэмэгдэнэ;

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг боловсронгуй болгож, орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцнэ;

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай халамжид хамрагдагсад зэрэг зорилтот бүлгийн иргэнийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний шинэ төрөл, хэлбэрүүдийг бий болгосноор хөдөлмөрийн нөөцийн ашиглалт нэмэгдэнэ;

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг ажилгүй иргэн, ажил хайгч, зорилтот бүлгийн иргэний онцлог, хэрэгцээ, нөхцөл байдалд нийцүүлэн дэс дараатайгаар хэрэгжүүлэх багц үйлчилгээ байдлаар тогтвортой хэрэгжүүлэх замаар үйлчилгээг хэрэглэгч төвтэй бүтэц, кейс менежментийн тогтолцоонд шилжүүлнэ;

5. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхижуулах тогтолцоо бэхжиж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл сайжирна;

6. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн төдийгүй хөдөлмөрийн зах зээлийг ажиглах, дүн шинжилгээ хийх талбар болгон хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны чадавхийг нэмэгдүүлэх, бүтэц, чиг үүргийг тодорхой болгох, хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, дунд, урт хугацааны таамаглалыг тогтмол гүйцэтгэж, үр дүнг бодлого, шийдвэрт тусгах нөхцөл бүрдэнэ;

7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, шаардлагатай үйлчилгээ, арга хэмжээг хувийн болон мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, аутсорсинг хийх ажлыг зохион

байгуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгож, чиг үүргийг шинэчилснээр үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр нөлөө дээшилнэ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцсэн байдлаар боловсруулна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Ахмад настны тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Статистикийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас гадна 2011 онд батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах болно.

--- оОо ---